



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын Мандал сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Си Пи Ти Эй Аудит ХХК
Утас: 77233030
Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
МАНДАЛ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.ЭНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын “Мандал” сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын “Мандал” сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 40.8 хувиар өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 47 хөтөлбөр, арга хэмжээг

тусган бүрэн хэрэгжүүлж, аймгийн Боловсролын газартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>288,355,477.12</u>	<u>731,532,714.91</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	123,841,179.86	400,450,361.92
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	123,841,179.86	400,450,361.92
3121	Төгрөг	123,841,179.86	400,450,361.92
31211	Төрийн сангийн харилцах	112,875,462.34	380,094,144.40
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	10,965,717.52	20,356,217.52
33	АВЛАГА	757,173.93	40,852,223.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	624,962.00	999,962.00
335	Бусад авлага	132,211.93	39,852,261.93
33510	Байгууллагаас авах авлага	83,242.64	39,803,292.64
33520	Хувь хүмүүсээс авах авлага	48,969.29	48,969.29
35	БАРАА МАТЕРИАЛ	163,757,123.33	290,230,129.06
351	Түүхий эд материал	102,103,274.51	163,934,144.24
35110	Тусгай зориулалттай материал	101,820,374.51	163,394,354.24
35130	Эм боох материал	282,900.00	539,790.00
354	Хангамжийн материал	61,653,848.82	126,295,984.82
35410	Бичиг хэргийн материал	749,120.00	838,500.00
35420	Аж ахуйн материал	59,215,854.82	114,792,572.82
35440	Түлш, шатах тослох материал	-	507,000.00
35450	Барилгын засварын материал	342,900.00	8,536,100.00
35460	Хүнсний материал	1,345,974.00	1,621,812.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,672,554,108.18</u>	<u>3,652,481,028.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,672,554,108.18	3,652,481,028.78
392	Биет хөрөнгө	3,492,554,108.18	3,472,481,028.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,298,882,848.44	3,298,882,848.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(345,140,744.87)	(408,678,923.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,390,495.00	82,390,495.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,656,165.20)	(44,484,247.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	513,219,814.60	715,103,304.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(171,283,127.91)	(291,663,680.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	249,986,898.88	271,251,998.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(143,113,056.34)	(187,587,912.11)
39217	Ном	37,267,145.58	37,267,145.58
393	Биет бус хөрөнгө	180,000,000.00	180,000,000.00
39301	Програм хангамж	3,829,670.00	3,829,670.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,829,670.00)	(3,829,670.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	180,000,000.00	180,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,960,909,585.30</u>	<u>4,384,013,743.69</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>58,172,436.00</u>	<u>158,928,473.70</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,172,436.00	158,928,473.70
413	Өглөг	58,172,436.00	158,928,473.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	790,681.00	866,620.12
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	57,381,755.00	60,511,928.00

4136	Бусад өглөг	-	97,549,925.58
41361	Байгууллагад төлөх өглөг	-	97,549,925.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,902,737,149.30	4,225,085,269.99
51	Засгийн газрын хувь оролцоо	3,902,737,149.30	4,225,085,269.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	180,000,000.00	180,000,000.00
51101	Өмч: - төрийн	180,000,000.00	180,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,722,737,149.30	4,045,085,269.99
51210	Өмнөх үеийн үр дүн	3,687,996,461.25	3,722,737,149.30
51220	Тайлант үеийн үр дүн	34,740,688.05	322,348,120.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,960,909,585.30	4,384,013,743.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,526,709,724.10	3,779,246,907.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,007,474.50	297,585,907.73
120	Нийтлэг татварын бус орлого	140,007,474.50	297,585,907.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,626,443.60	121,082,438.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	62,002,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,626,443.60	59,079,738.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	126,278,030.90	91,937,590.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,103,000.00	84,565,879.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,386,702,249.60	3,481,661,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,994,163,900.00	3,031,236,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,994,163,900.00	3,031,236,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,936,949.60	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,936,949.60	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	370,601,400.00	450,424,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	370,601,400.00	450,424,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,490,651,794.50	3,456,898,787.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,490,651,794.50	3,456,898,787.04

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,414,980,187.84	3,419,948,291.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,437,541,786.96	2,085,810,390.00
210101	Үндсэн цалин	1,001,476,223.17	1,389,950,265.00
210102	Нэмэгдэл	352,133,429.56	596,941,516.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,324,349.00	
210104	Урамшуулал	68,607,785.23	98,918,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,914,327.00	254,150,611.00
210201	Тэтгэврийн даатгал	123,005,334.87	172,753,212.03
210202	Тэтгэмжийн даатгал	14,486,605.87	20,771,898.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,571,524.45	10,323,714.97
210204	Ажилгүйдлийн даатгал	2,802,692.33	9,976,256.48
210205	Эрүүл мэндийн даатгал	28,048,169.48	40,325,528.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,094,873.34	444,736,120.73
210301	Гэрэл, цахилгаан	23,226,587.34	25,438,301.73
210302	Түлш, халаалт	355,313,662.00	385,424,795.00
210303	Цэвэр, бохир ус	29,554,624.00	33,873,024.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,442,393.00	35,281,060.30
210401	Бичиг хэрэг	17,239,540.00	17,471,980.00
210402	Тээвэр, шатахуун	6,942,343.00	4,846,190.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,079,710.00	12,416,690.00
210408	Бараа материал акталсны зардал	1,180,800.00	546,200.00
2105	Нормативт зардал	107,556,870.00	216,914,013.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,835,310.00	1,582,660.00
210502	Хоол, хүнс	105,721,560.00	215,331,353.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,544,060.00	15,082,710.00
210604	Урсгал засвар	16,544,060.00	15,082,710.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,792,800.00	38,115,716.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,123,200.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,669,600.00	38,115,716.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,093,077.54	329,857,669.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,529,485.00	86,635,999.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,563,592.54	243,221,669.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,671,606.66	36,950,495.27

2132	Бусад урсгал шилжүүлэг	74,078,747.00	36,944,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,078,747.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	36,944,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,592,859.66	5,995.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,592,859.66	5,995.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>36,057,929.60</u>	<u>322,348,120.69</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,317,241.55	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,317,241.55	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,317,241.55)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,740,688.05</u>	<u>322,348,120.69</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,396,328,693.20</u>	<u>3,602,743,438.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,626,443.60	121,082,438.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,626,443.60	121,082,438.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,626,443.60	121,082,438.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	62,002,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,626,443.60	59,079,738.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,386,702,249.60	3,481,661,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,994,163,900.00	3,031,236,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,994,163,900.00	3,031,236,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,936,949.60	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,936,949.60	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	370,601,400.00	450,424,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	370,601,400.00	450,424,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,244,644,970.96</u>	<u>3,326,134,255.94</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,244,644,970.96	3,326,134,255.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,108,598,089.30	3,141,340,351.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,437,882,268.96	2,085,959,418.00
210101	Үндсэн цалин	1,001,816,705.17	1,390,099,293.00
210102	Нэмэгдэл	352,133,429.56	596,941,516.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,324,349.00	
210104	Урамшуулал	68,607,785.23	98,918,609.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,043,725.00	254,793,770.84
210201	Тэтгэврийн даатгал	123,134,732.87	173,396,371.87
210202	Тэтгэмжийн даатгал	14,486,605.87	20,771,898.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,571,524.45	10,323,714.97
210204	Ажилгүйдлийн даатгал	2,802,692.33	9,976,256.48
210205	Эрүүл мэндийн даатгал	28,048,169.48	40,325,528.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	355,731,400.34	438,424,794.73
210301	Гэрэл, цахилгаан	23,226,587.34	25,438,301.73
210302	Түлш, халаалт	301,113,060.00	385,424,795.00
210303	Цэвэр, бохир ус	31,391,753.00	27,561,698.00
2105	Нормативт зардал	28,581,845.00	28,870,703.00
210502	Хоол, хүнс	28,581,845.00	28,870,703.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,999,960.00	16,494,010.00
210604	Урсгал засвар	17,999,960.00	16,494,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,824,800.00	60,580,791.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,123,200.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,701,600.00	60,580,791.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,534,090.00	256,216,864.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,065,490.00	233,481,764.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,468,600.00	22,735,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,046,881.66	184,793,903.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,454,022.00	184,787,908.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	134,454,022.00	147,843,408.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	36,944,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,592,859.66	5,995.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,592,859.66	5,995.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>151,683,722.24</u>	<u>276,609,182.06</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	55,573,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,573,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	55,573,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,573,800.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(55,573,800.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	96,109,922.24	276,609,182.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,731,257.62	123,841,179.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	123,841,179.86	400,450,361.92

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,000,000.00	3,687,846,343.25	3,867,846,343.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	150,118.00	150,118.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,000,000.00	3,687,996,461.25	3,867,996,461.25
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	34,740,688.05	34,740,688.05
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,000,000.00	3,722,737,149.30	3,902,737,149.30
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,000,000.00	3,722,737,149.30	3,902,737,149.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,000,000.00	3,722,737,149.30	3,902,737,149.30
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	322,348,120.69	322,348,120.69
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,000,000.0	4,045,085,269.99	4,225,085,269.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,693,879,100.00	3,320,518,760.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,693,879,100.00	3,320,518,760.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,486,972,200.00	3,135,730,851.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,373,267,000.00	2,085,959,418.00
210101	Үндсэн цалин	1,510,703,300.00	1,390,099,293.00
210102	Нэмэгдэл	801,571,400.00	596,941,516.00
210104	Урамшуулал	60,992,300.00	98,918,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	296,658,400.00	254,793,770.84
210201	Тэтгэврийн даатгал	201,727,700.00	173,396,371.87
210202	Тэтгэмжийн даатгал	23,732,700.00	20,771,898.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,866,300.00	10,323,714.97
210204	Ажилгүйдлийн даатгал	11,866,300.00	9,976,256.48
210205	Эрүүл мэндийн даатгал	47,465,400.00	40,325,528.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,424,800.00	438,424,794.73
210301	Гэрэл, цахилгаан	25,438,300.00	25,438,301.73
210302	Түлш, халаалт	385,424,800.00	385,424,795.00
210303	Цэвэр, бохир ус	27,561,700.00	27,561,698.00
2105	Нормативт зардал	37,901,300.00	28,870,703.00
210502	Хоол, хүнс	37,901,300.00	28,870,703.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,500,000.00	16,494,010.00

210604	Урсгал засвар	16,500,000.00	16,494,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,583,000.00	60,580,791.10
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,583,000.00	60,580,791.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,637,700.00	250,607,364.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	240,902,600.00	227,872,264.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,735,100.00	22,735,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,906,900.00	184,787,908.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	206,906,900.00	184,787,908.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	169,962,400.00	147,843,408.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,944,500.00	36,944,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,693,879,100.00	3,587,737,442.73
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,031,236,200.00	3,031,236,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,031,236,200.00	3,031,236,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	450,424,800.00	450,418,804.73
132001	Орон нутгийн төсвөөс	450,424,800.00	450,418,804.73
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	104,442,300.00	106,082,438.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	63,492,300.00	4,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	40,950,000.00	101,582,438.00
1200043	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	107,775,800.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	112,875,462.34
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	380,094,144.40

Гурав. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 10,425.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,103.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,260.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,060.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,103.2 мянган төгрөгийн 3 алдаа илрүүлж, аудитын явцад залрууллаа.

1. Цалин, НДШ-ийн зардал 710.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан
2. 76,5 мянган төгрөгийн өглөг дутуу тайлагнасан
3. НДШ-ийн тайланд ажилчдын цалинг 316.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 20 дугаар зүйлийн 20.2.3 /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заасныг зөрчсөн байна. Энэ нь ангилал болон ойлгомжтой байх, үнэн зөв ба үнэлгээ гэсэн багтамж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Залруулаагүй алдаа:

Аудитаар илэрсэн нийт 9,321.8.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 3 албан шаардлага хүргүүлээ

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Ажилчдад олгосон урамшуулалт цалингаас 3,279.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3/Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:/, 6.3.1/цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:/, 7.1.1 /ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;/, 21 дүгээр зүйлийн 21.1./Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар/заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.1.2 Сахилгын шийтгэлтэй албан хаагчдын сахилгын хугацаа дуусаагүй буюу дууссан тухай мэдэгдээгүй байхад 1,891.7 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/ , Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 -д /Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг сахилгын шийтгэлгүйд тооцно/ заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

3.2.1 Насжилт өндөртэй нийт 1,547.8 мянган төгрөгийн /**өглөг 790.7 мянган төгрөг, авлага 757.2 мянган төгрөг**/ авлага, өглөгийг барагдуулах ажил зохион байгуулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8./төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх./16 дугаар зүйлийн 16.5.4./төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6./Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна./, 13.7/Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, 20 дугаар зүйлийн 20.1.4/хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх/, 20.2.5/дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6./эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2.2 Нягтлан бодогч, нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,513.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5

дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”, Засгийн газрын 2023 оны 442-р тогтоолын хавсралтаар өөрчлөлт орсон 2.2 “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.”, Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалт/ заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2.3 Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 27, зарлагын 5, төсөв, хөрөнгөтэй холбоотой 2 шийдвэр тус тус мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт 75.4 хувьтай, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1/мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/ , 6 дугаар зүйлийн 6.4.8 /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр/заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

1.Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин, НДШ-ийн зардал илүү тайлагнасан	1	710.3			1	710.3	1	710.3				
Өглөг дутуу тайлагнасан.	1	76.5	1	76.5			1	76.5				
НД-д ажилчдын цалинг дутуу тайлагнасан.	1	316.4	1	316.4			1	316.4				
Дүн	3	1,103.2	2	392.6	1	710.3	1	1,103.2		-	-	-

2.Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Насжилт өндөртэй 790.7 мянган төгрөгийн өглөг, 757.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй,	1	1,547.8			1	1,547.8						
Нягтлан бодогч, нярвын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон.	1	2,513.0			1	2,513.0						
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал цалин олгосон	1	1,981.7	1	1,981.7								
Ажилчдад олгосон урамшуулалт цалингаас хувь хүний орлогын албан татвар суутгаагүй.	1	3,279.3	1	3,279.3								
Дүн		9,321.8	2	5,261.0	2	4,060.8		-				

3.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 27, зарлагын 5, төсөв, хөрөнгөтэй холбоотой 2 шийдвэр тус тус мэдээлээгүй, хуулийн хэрэгжилт 75.4 хувьтай, өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	-			1	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			